



**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ  
23 ДУГААР СУРГУУЛИЙН БАГА АНГИЙН БАГШ Д.СОДГЭРЭЛИЙН  
2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019.06.10

**Даасан анги: 5<sup>д</sup> анги**

**Заадаг хичээл: Монгол хэл, Математик, Хүн ба байгаль, Хүн ба нийгэм, Дүрслэх урлаг, Иргэний боловсрол, Амьдрах чадварт суралцах, Хичээлээс гадуурх ажил**

**АГУУЛГА:**



# БИД НЭГ АНГИЙНХАН



Манай анги 61 суралцагчтай. Үүнээс: 35 охид, 26 хөвгүүдтэй.

## БИДНИЙ ЗОРИЛГО:

**ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЬЕ.**

## БИДНИЙ ЗОРИЛТ:

1. Эх хэлээ дээдлэх
2. Бие даах, багаар ажиллах чадвараа хөгжүүлэх
3. Мэдлэг чадвараа ахиулах

## 1. МЭДЛЭГ ЧАДВАРЫН АХИЦ, АМЖИЛТ

Ээлжит хичээлийн хэрэглэгдэхүүнийг сайтар бэлтгэх, сурагч бүрт хүрч ажиллах, сурагчдын сурлагын чанарт гарч буй ахиц амжилтыг тооцон ажиллах, сурагчдад илүү ихийг хийх хүсэл тэмүүлэлд хөтлөхөд чиглэсэн дараах үйл ажиллагааг явуулж ирлээ.

Хичээлийн жилийн эхэнд сурагчдын мэдлэг чадварын гарааны үнэлгээг тогтоосон ба улирал бүр мэдлэг чадварын сорил авч анализ хийн ажиллалаа. Улирлын дунд явцын үнэлгээний шалгалтуудыг тогтмол авч дахин шалгуулж дүнгээ сайжруулах боломжийг сурагчдад өгөн ажиллав.

Монгол хэл, математик, хүн ба байгаль, дүрслэх урлаг хичээлийн хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг секцийн багш нартай хамтран боловсруулж, БҮТ-ийн даалгаврын сангаас ажиллаж шалгалт авч явцын дүгнэлт хийж ирлээ.

### СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН БОЛОВСРУУЛАЛТ

№	Судлагдхууны нэр	Бүлэг сэдэв	НЭГЖ ХИЧЭЭЛ		ЭЭЛЖИТ		Сайжруулсан хичээл
			боловсруулбал зохих	боловсруулж баталгаажуулсан	боловсруулбал зохих	боловсруулж баталгаажуулсан	
1	Монгол хэл	7	7	7	112	112	2
2	Математик	2	7	7	80	80	1
3	Хүн байгаль	4	4	4	32	32	1
4	Хүн нийгэм	2	2	2	16	16	0
5	Дүрслэх урлаг	2	2	2	32	32	0

### СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ ХИЧЭЭЛ ЗААХ

Судлагдахуун	Заах цаг	Заасан цаг	Тасарсан цаг	Нөхсөн
Монгол хэл	112	112	0	
Математик	80	80	0	
Хүн байгаль	32	32	0	
Хүн нийгэм	16	16	0	
Дүрслэх урлаг	32	32	0	
Иргэний боловсрол	16	16	0	
Хичээлээс гадуурх ажил	16	16	0	
Амьдрах чадварт суралцах	16	16	0	

**СТАНДАРТ ХЭРЭГЖИЛТ  
МЭДЛЭГ ЧАДВАРЫН СОРИЛ.**

Гарааны үнэлгээ тогтоох мэдлэг чадварын сорилыг Монгол хэл, Математик, Хүн ба байгалийн хичээлүүдээр ахицыг тооцон ажиллаж улсын шалгалтаар амжилттай үнэлэгдсэн. .



**Дэмжлэг хэрэгтэй сурагчидтай ажилласан байдал**

№	Сурагчдын нэр	Шалтгаан	Ажилласан байдал
1	Э. Ангараг	Ар гэрийн анхаарал халамж дутмаг, Анхаарал тогтворгүй, гэрийн даалгавар огт хийдэггүй	<ul style="list-style-type: none"> <li>- Өдөр бүр дэмжин тусалж ажилладаг. Ангарагийн ээжтэй нь уулзаж ярилцан зөвлөгөө өгсөн, ганцаарчилсан давтлага хийсэн, гадуур нэмэлт давтлаганд явуулсан боловч ахиц төдийлөн гарахгүй байгаа.</li> <li>- Ананд одод тохирсон даалгавар өгч чадваржуулах тал дээр</li> </ul>
2	С.Ананд-Од	Зөв, цэвэр бичих, бие даан ажиллах, өөрийгөө илэрхийлэх чадвар сул, хичээлээс өвчний шалтгаанаас чөлөө их авдаг Монгол хэлний хичээл дээр	

		анхааран хэл яриаг хөгжүүлнэ.	анхаарч ажилласнаар тодорхой ахиц гарч байгаа. - Өвдсөн үед гэрээр хичээлийг нь давтуулахад зөвлөгөө өгч ажилладаг.
3.	Б.Мишээл	Шилжиж ирсэн бүх хичээлээр хоцрогдолтой.	Ээжтэй нь ярилцаж зөвлөгөө өгсөн. Нэмэлт давтлаганд явж байгаа.

Цэвэр бичих чадварыг сайжруулах шаардлагатай 9 сурагч, сонголын чээж бичиг бичихэд 5-с дээш үгийг алдаатай бичдэг 7 сурагч, уншиж ойлгосноо ярих, үзэл бодлоо илэрхийлэх чадвар сул 4 сурагч байгааг ээлжит хичээл бүр дээр анхааран дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Анги нийтээр нь бие даан сурах арга барил эзэмших, учир шалтгааныг ухааран ойлгох чадвартай болгоход анхааран өгүүлбэртэй бодлого өдөр бүр боддог.


## 2. ТӨЛӨВШИЛ

Сурагчдыг бусдыг хүндэтгэн харилцдаг, гэр бүл,найз нөхдөө хайрлан тусалж дэмждэг, биеэ зөв авч явдаг, ёс заншил, байгаль орчноо хайрлан хамгаалдаг, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг зөв дадал хэвшил, төлөвшилтэй болгох зорилгоор:

- ❖ МОНГОЛ ХҮН – МОНГОЛ БАХАРХАЛ сэдэвт өдөрлөгөөр Монгол уламжлал, ёс заншил, хэл соёлоос суралцан АХА тэмцээн зохион байгуулсан.
- ❖ Орон нутгийн амьдрал ахуй, байгаль орчин, уламжлалт түүх соёлтой танилцах зорилгоор Эко аялалд хамт олноороо анх удаа оролцсон нь сурагчдын харилцан ойлголцох, биеэ зөв авч явах, байгальтай зүй зохистой харилцах, хогийг ангилан хаях талаар дадлага хийж их зүйл сурч авлаа.
- ❖ Дүрэмт хувцсаа логожуулж, биеийн тамирын хичээлд орохдоо сольж формоо эвхэж хурааж сурч байна.
- ❖ Салаан дарга нар гэрийн даалгаврын биелэлтийг өдөр бүр шалгаж, бие биедээ шаардлага тавьснаар сурагчид гэрийн даалгавраа тогтмол хийж хэвшиж байна.
- ❖ Ангийн хурлыг хийж зүй бус үг хэллэг хэрэглэн бусдыг доромжилдог, дэг журам баримталдаггүй сурагчдыг авч хэлэлцэн анхааруулга өгөн алдаа дутагдалаа засах талаар ярилцлаа.



# ЗӨВ ЗАН ЧАНАР




## 3. АВЬЯАС

Сурагчдыг ном унших хүсэл тэмүүлэлтэй болгох, танин мэдэхүй, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, урлан бүтээх чадвар, авьяасыг нээн хөгжүүлэх зорилгоор:

- ❖ Сурагч бүрийг сонирхлын дэгуу дугуйланд суралцах даалгавар өгснөөр ангийн сурагчдын 91% буюу 53 сурагч 1-3 дугуйланд суралцан өөрийгөө хөгжүүлж байна.
- ❖ “Нэг сурагч-нэг ном” аянд нэгдэж сургуулийн номын санд 54 ширхэг ном хандивлан сурагчдыг ном унших дадалд сургаж, танин мэдэхүйг хөгжүүлэхэд анхааран ажилласан.
- ❖ Бүтээлийн үзэсгэлэнг ангидаа 3 удаа болон сургуульд 2 удаа гаргасан.
- ❖ “Сонирхолд нь нийцүүлэн хөгжүүлэх” дугуйланд 30 сурагч суралцаж урилга, мэндчилгээ хийж чимэглэх урлагт суралцсан.
- ❖ Мэдээлэл цуглуулан боловсруулах, илтгэх чадварыг хөгжүүлэх зорилгоор Илтгэлийн уралдаан зохион явуулсан.
- ❖ “Мудра арт” урланд очиж бүтээл хийн зурах будах чадварыг хөгжүүлсэн.
- ❖ Ангиараа “Бий биелгээ” бүжиг бүжиглэж сурсан.
- ❖ Ангиараа “Халуун элгэн нутаг” дууг бишгүүрээр тоглож сурсан.

## Дугуйлан секцэд хамрагдаж буй байдал



## 2018-2019 оны хичээлийн жилд 5д ангийн сурагчдын үзүүлсэн амжилт

№	Сурагчийн нэр	Хугацаа	Тэмцээн уралдааны нэр	Амжилт
1.	Э.Саяжаргал	2018-11 сар	Сургуулийн аварга шалгаруулах шатрын тэмцээн	Мөнгөн медаль
2.	Э.Саяжаргал	2018-11 сар	Их нүүдэл ЧД-ийн аварга шалгаруулах шатрын тэмцээн	Мөнгөн медаль
3.	Э.Саяжаргал	2018-12 сар	Монгол хэлний олимпиад	Хүрэл медаль
4.	У.Цолмон	2018-12 сар	Математик сонины нэрэмжит тэмцээн	Хүрэл медаль
5.	Б.Баясгалан	2018-11 сар	Монгол хэлний олимпиад	Мөнгөн медаль
6.	Г.Нандин-Эрдэнэ	2018-11 сар	Монгол хэлний олимпиад	Хүрэл медаль
7.	Г.Оюунтөгс	2018-11 сар	Монгол хэлний олимпиад	Мөнгөн медаль
8.	М.Бөртэ	2018-12 сар	Монгол хэлний олимпиад	Хүрэл медаль
9.	Д.Маралмаа	2018-10 сар	Сэтгэх чадварын сорилго	Топ үнэлгээ
10.	Д.Маралмаа	2018.12.23	Ангийн шилдэг сурагч	Сургуулийн бэлэг
11.	Хамт олноороо	2018-12-18	“Язгуур урлаг” төрлөөр	Аварга
12.	А.Оюунтөгс	2019.04 сар	“Кенгуру 2019” олимпиад	Хүрэл медаль, I зэргийн диплом
13.	А.Оюунтөгс	2018.12 сард	МСХолбоо	“Эрдэм –Оюу” хүрэл медаль
14.	5 сурагч	2019.04 сар	Кенгуру 2019 олимпиад	II ба III зэргийн диплом
15.	У.Цолмон	2019.04 сар	“Кенгуру 2019” олимпиад	Хүрэл медаль, I зэргийн диплом
16.	Э.Саяжаргал	2018.12 сард	МСХолбоо	“Эрдэм –Оюу” хүрэл медаль
17.	Н.Биндэръяа	2019.06.01	МУ-ын ерөнхийлөгчийн нэрэмжит гар зургийн уралдаан	Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал

### 4.ЭРҮҮЛ МЭНД

**Суралцагчдыг эрүүл чийрэг бие бялдартай, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох зорилгоор: сургуулийн эмч, нийгмийн ажилтан нартай хамтран доорх ажлуудыг зохион байгуулсан.**

- ❖ Сургуулийн эмчтэй хамтран сурагчдын биеийн жин, өндрийн судалгааг хичээлийн жилийн эхэн ба төгсгөлд авч хүүхдийн өсөлт хөгжлийг эцэг эхчүүдэд танилцуулдаг.
- ❖ Сурагчдад гар ба шүдээ зөв угаах видео бичлэгийг үзүүлэн дадал хэвшил болгох зөвлөгөө өгсөн.

- ❖ Витаминжүүлэх аяныг жил бүрийн 11, 4 дүгээр саруудад зохион байгуулж байна.
- ❖ Сурагчдын зорчих хөдөлгөөний судалгаа авсан.
- ❖ Цүнхийг цацруулагчтай болгосон.
- ❖
- ❖ Сурагчид томуу болон томуу төст өвчин түүнээс урьдчилан сэргийлэх мэдээлэл боловсруулж бие биедээ зөвлөгөө өгсөн.
- ❖ Үдийн цайны орчинг бүрдүүлэх, сурагч бүр орчноо цэвэрлэх, жижүүр сурагчид зөөгчийн хувцас өмсөн үдийн цай тараах ажлыг хийж сурлаа.
- ❖ Нийслэлийн ЧД-ийн Цагдаагийн хэлтсээс мэргэжилтэн ирж, сүүлийн үед бага насны хүүхдүүд гэмт хэргийн хохирогч болж байгаа эрсдлүүдийг ухуулан таниулж, гэмт хэргийн хохирогч болохгүй байх талаар мэдээлэл өгч, ярилцлага хийлээ.

### **5.СЭТГЭЛ ХАНАМЖ.**

Эцэг эхчүүдийг сургалт хүмүүжлийн үйл ажиллагаатай танилцуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх, санал бодлыг хүлээн авч хамтран ажиллаж зорилгоор 2 ажил төлөвлөснөөс эцэг эхчүүдийг 4 групп болгон ажиллаж дараах 3 ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

- ❖ “Багш-Эцэг эх” өдөрлөг
- ❖ Гуравласан гэрээ байгуулах
- ❖ Эцэг эхийн хурлаар аргагүйн зөвлөгөө өгөх “Бид ирээдүй өөд хамтдаа” тайлант өдөрлөг зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.

### **ДҮГНЭЛТ**

Суралцагчдад хүнтэй мэндлэх, сургуулийн анги танхимд жагсаалаар явах, хогийг зориулалтын саванд хийх, баярласнаа илэрхийлэх зэрэг зөв дадал хэвшил төлөвшүүлэх, анхааралтай сууж бусдыг сонсох, сурах арга барил эзэмшүүлэх, сурагч нэг бүрийг шүлэг уран тод унших, зөв унших, бичих, бодох чадварыг хөгжүүлэх, сургалтын орчин бүрдүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг эцэг эхчүүдтэйгээ хамтран амжилттай зохион байгууллаа.

**Тайлан бичсэн бага боловсролын багш Д.Содгэрэл.**